



ТУХАЙН ШАТНЫ СОНГУУЛИЙН  
ХОРООНД

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.04 № 290

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

#### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

#### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

009020347


## Дүгнэлт

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Монгол ардын нам”-ын орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Монгол ардын нам”-д

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ..... /Ш.МӨНХБАЯР/





**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР  
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ 2025-2028 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024 он

# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2025-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## Үндэслэл:

Хонгор сумын Монгол Ардын намын хорооны 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, "Алсын хараа-2050", Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний төлөвлөгөө, Шинэ хоршоо-Чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөө, Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон бусад бодлогын баримт бичгийг үндэслэн хүн ам, эдийн засаг, хүний хөгжлийн хангах, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, засаглалыг сайжруулах болон бүс орон нутгийг хөгжүүлэх дараах таван багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх, зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

## Агуулга:

- НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
- ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО
- ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО
- ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
- ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

№	Бүлэг, ангилал	Нэг. Хүний хөгжлийн бодлого	Хоёр. Эдийн засаг, засаглалын бодлого	Гурав. Хөдөө аж ахуйн бодлого	Дөрөв. Ногоон хөгжлийн бодлого	Тав. Орон нутгийн хөгжлийн бодлого	Нийт
1	Зорилт	3	4	2	1	4	14
2	Арга хэмжээ	43	32	19	9	34	137

## Зорилго:

Орон нутагт чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, дэд бүтэц хөгжсөн, нийгмийн суурь үйлчилгээнүүдийн чанар хүртээмж стандартад нийцсэн орчин үеийн сум болох

## НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 1.1 Боловсрол, соёл, спортын салбарыг хөгжүүлэх чиглэлээр:

- 1.1.1 Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулна.
- 1.1.2 Боловсролыг дэмжих дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 1.1.3 14 дүгээр сургуулийн хичээлийн А,Б, 11-р сургуулийн Б байрны засвар шинэчлэлийн ажлын зураг төсвийг боловсруулж, засварын ажлыг эхлүүлнэ
- 1.1.4 Ерөнхий боловсролын байгууллагуудын гадна хашаа, спортын талбайг шинэчлэх ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх
- 1.1.5 Цэцэрлэг сургууль бүрийн материаллаг баазыг үе шаттайгаар нэмэгдүүлж, сурах орчин нөхцөлийг сайжруулна
- 1.1.6 Салхит 3 дугаар багийн 100 хүүхдийн багтаамжтай шинэ цэцэрлэгийг үйл ажиллагааг тогтмолжуулах, хамран сургалтыг нэмэгдүүлнэ
- 1.1.7 Сургуулийн хүүхдийн автобусны үйлчилгээг сайжруулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ
- 1.1.8 11-р сургуулийн спорт заалны засварын ажлыг хийж хэрэгжүүлнэ

- 1.1.9 Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж буй сурлагын амжилтаараа тэргүүлэгч сурагчдад зориулсан тэтгэлэг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- 1.1.10 Дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд хэрэглээний халуун усаар хангана
- 1.1.11 Ерөнхий боловсролын сургуулиудад стандартын шаардлага хангасан кабинет, лабораторийн тоог нэмэгдүүлнэ
- 1.1.12 СӨБ-ийн хамран сургалтыг нэмэгдүүлэх хүрээнд нүүдлийн бүлгийн материаллаг баазыг нэмэгдүүлнэ
- 1.1.13 16-р цэцэрлэгийн агааржуулалтын системийг сайжруулж, нэмэлт халаалтын төхөөрөмжүүдийг нэмэгдүүлнэ
- 1.1.14 Боловсролын байгууллагуудын сургалтын орчныг стандартад нийцүүлнэ
- 1.1.15 Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хүрээнд спортын дэд хөтөлбөрийг залуучуудын оролцоотойгоор хэрэгжүүлнэ
- 1.1.16 ЕБС-ын гадаа спортын талбайн тоног төхөөрөмжийг шинэчилнэ
- 1.1.17 ЕБС-ын сургуулиудын сурагчдыг спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэх хүрээнд мэргэжлийн багш, дасгалжуулагчийн нөөцийг нэмэгдүүлж, чадавхыг нэмэгдүүлэх
- 1.1.18 Нийтийн спортын орчин нөхцөлийг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлнэ
- 1.1.19 Соёлын үйлчилгээг иргэдэд чанартай хүргэх хүрээнд материаллаг баазыг тогтмол шинэчилж, боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана
- 1.1.20 "Бүх нийтийн соёлын боловсрол-2" арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлнэ
- 1.1.21 Үндэсний соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах арга хэмжээг дэмжин ажиллана
- 1.1.22 Орон нутгийн түүх дурсгал, түүхийн үнэт олдворыг иргэдэд таниулах зорилгоор соёлын дэргэдэх музейн танхимын үйл ажиллагааг сайжруулна
- 1.1.23 Сургуулиудын номын санг шинэчилж, номын сангийн баяжилтыг хийнэ
- 1.1.24 Цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны орц найрлагыг тогтмол хянаж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчлэхэд анхаарч ажиллана.

**1.2 Эрүүл мэндийн чиглэлээр:**

- 1.2.1 Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцин, дархлаажуулалтад бүрэн хамруулна
- 1.2.2 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээний үед ажиллах эмч мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах дадлага сургуулилтыг тогтмол зохион байгуулна
- 1.2.3 Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн цаг үед нь нийцүүлэн шинэчлэх ажлыг тогтмол хэрэгжүүлнэ
- 1.2.4 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх дадал заншлыг хэвшүүлэх, сургалт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах
- 1.2.5 Эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд нийт иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг эрчимжүүлнэ
- 1.2.6 Сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх хүрээнд сумын ЭМТ-д рентген аппаратыг нийлүүлнэ
- 1.2.7 Иргэдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хүрээнд ЭМТ-ийн барилгын их засварын ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 1.2.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эмчилгээ, оношилгоо, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд саадгүй хамрагдах жишиг орчин нөхцөлийг ЭМТ-д бүрдүүлнэ.

### 1.3 Нийгмийн хамгааллын чиглэлээр:

- 1.3.1 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоотой хүүхдийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.2 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг ажиллах орчин нөхцөлөөр хангаж, мэргэшүүлэх тал дээр анхаарч ажиллана
- 1.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг сайжруулах хүрээнд "Хөгжлийн төв"-ийн үйл ажиллагааг сайжруулна
- 1.3.4 Хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах замаар зорилтод бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлнэ
- 1.3.5 Суманд үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин ажиллана
- 1.3.6 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ
- 1.3.7 Хүүхдийг багаас нь харилцааны зөв хэвшилтэй, ёс зүйтэй иргэн болж төлөвших арга хэмжээг дэмжин ажиллана
- 1.3.8 Ахмадын А байрны засвар шинэчлэлийн ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 1.3.9 Нийтийн бие засах газрыг сумын төвд байгуулна
- 1.3.10 Малчдын амьдрах орчныг сайжруулах хүрээнд халуун усны газар байгуулна
- 1.3.11 Ахмад настан, Төрийн албан хаагчдын орон сууцыг ашиглалтад оруулж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ

### ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

#### 2.1 Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр:

- 2.1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийн хэрэгжилтийг жигд ханган биелүүлэх ажлыг зохион байгуулна
- 2.1.2 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг орон нутгийн төрийн болон төрийн өмчийн оролцоотой бүх байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлж, иргэдэд нээлттэй мэдээлэлдэг тогтолцоог нэвтрүүлнэ
- 2.1.3 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хяналтыг сайжруулна
- 2.1.4 Хоршоо хөгжүүлэх сангийн хүртээмжийг сайжруулах, тогтвортой хоршооны үйлдвэрлэлийг дэмжин ажиллана
- 2.1.5 Орон нутгийн төрийн болон төрийн өмчит байгууллагуудын хөрөнгө ашиглалт, бүртгэлийг сайжруулж, цахим технологийг нэвтрүүлнэ

#### 2.2 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр:

- 2.2.1 Төрийн бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна
- 2.2.2 Төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэлтийг эрчимжүүлж, хяналтыг сайжруулна
- 2.2.3 Төрийн бүх шатны байгууллагуудын архивын бичиг баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, стандартад нийцүүлж, цахимжуулна
- 2.2.4 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, шатлан дэвших нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ
- 2.2.5 "Цахим Дархан" аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд цахимаар төрийн үйлчилгээг хүргэх нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ
- 2.2.6 Төрийн байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд өрөө тасалгаа, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг тогтмол хэрэгжүүлнэ

2.2.7 Зулзага багийн төвийг нүүдлийн горимоор ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд старлинкийн интернэтэд холбон багийн иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулна

### **2.3 Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

- 2.3.1 Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах
- 2.3.2 Сумын хэмжээнд гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна
- 2.3.3 Цагдаагийн хэсгийн материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах
- 2.3.4 Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийж хэрэгжилтийг хангуулна
- 2.3.5 Гамшиг эрсдэлийн үед ашиглах техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, засвар үйлчилгээг тогтмолжуулна
- 2.3.6 Сумын аюулгүйн нөөцийг жил бүр бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулж нөөцийн саравчийг ашиглалтад оруулна
- 2.3.7 Газар зүйн нэрийн тодруулга, ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөг хийж дуусгаж, хэрэгжүүлнэ
- 2.3.8 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна
- 2.3.9 Гамшигийн эрсдэлийн нарийвчилсан төлөвлөгөөг хийж дуусгаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулна
- 2.3.10 Авто замын хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлж явган зорчигч, хүүхдүүдийн замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлийг бий болгоно
- 2.3.11 Эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн насны иргэдийн цэргийн боловсролыг дээшлүүлнэ
- 2.3.12 Зуслангийн бүс орчимд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд цагдаагийн хэсгийг байгуулах ажлыг холбогдох газруудтай хамтарч хэрэгжүүлэх
- 2.3.13 Сумын хэмжээнд гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгорр камержуулалтыг тогтмол нэмэгдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

### **2.4 Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр:**

- 2.4.1 Иргэдийг хоршоолох, хамтарч жижиг дунд бизнес эрхлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжин ажиллана
- 2.4.2 Сумын бизнес хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, сумын нэрийн брэнд бүтээгдэхүүн гаргах үйлдвэрлэлийг дэмжин ажиллана
- 2.4.3 "Халамжаас хөдөлмөрт" бодлогын хүрээнд зорилтод бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөр төсөлд хамруулна
- 2.4.4 "Шинэ хөдөө" төслийг орон нутагт эрчимжүүлж, малчин, тариаланч өрхийн үйлдвэрлэл эрхлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ
- 2.4.5 Олон улсын зам дагуу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжин ажиллаж, худалдааны бүс байгуулна
- 2.4.6 Хоршоо хөгжүүлэх сангаар төсөл хэрэгжүүлэгч нарыг ажлын байр нэмэгдүүлэх, тэргүүлэх чиглэлээр үйлдвэрлэл эрхлэхийг бодлогоор дэмжин ажиллана
- 2.4.7 Гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх хувийн хэвшлийн санаачилгыг бүх талаар дэмжиж туслах аж ахуйн бүсчлэл байгуулж, дэд бүтцийг шийдвэрлэнэ.

## **ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО**

### **3.1 Газар тариаланг эрчимжүүлэх чиглэлээр:**

- 3.1.1 Газар тариаланг эрчимжсэн мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх бодлого баримтална

- 3.1.2 Газар тариалан, хүнсний ногооны дундын аж ахуйн ашиглалтыг сайжруулна
- 3.1.3 Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх, дахин боловсруулах талаар гарсан санал санаачилгыг бодлогоор дэмжин ажиллана
- 3.1.4 Газар тариалан эрхлэгч, малчдын хамтын уялдаа холбоог сайжруулж, тэжээлийн ургамал тариалахыг бодлогоор дэмжинэ
- 3.1.5 Тариалангийн талбайг иргэд, ААН-ын оролцоотойгоор хашаажуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 3.1.6 Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх чиглэлээр иргэн, ААН-с гаргасан саналыг бодлогоор дэмжин ажиллана
- 3.1.7 Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, "Атар -4" аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 3.1.8 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорины аж ахуйг хөгжүүлэх замаар, хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрөл, тариалалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 3.1.9 Ургацын чанар, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд суманд Үр үржүүлгийн төв байгуулахыг бодлогоор дэмжинэ

### 3.2 Мал аж ахуйг эрчимжүүлэх чиглэлээр:

- 3.2.1 Алслагдсан бэлчээрийг усжуулах замаар бэлчээр ашиглалтыг сайжруулах бодлого баримтална
- 3.2.2 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжин, малын ашиг шимийг дээшлүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- 3.2.3 Малын халдварт өвчингүй бүс нутаг болох зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, МЭҮН-ийг чадавхжуулах, тоног төхөөрөмжийг шинэчилнэ
- 3.2.4 Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малын сүү хүлээн авах цэгийг үйл ажиллагааг эрчимжүүлж, тоог нэмэгдүүлэх
- 3.2.5 Бог, бод малын ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах
- 3.2.6 Зудын эрсдэлийг даван туулах "Өвөлжөө" төслийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулна
- 3.2.7 Малын гаралтай түүхий эдийг дахин боловсруулах үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ
- 3.2.8 Малчдын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд мал нядалгааны цэгийг байгуулж, ашиглалтад оруулна
- 3.2.9 Малын тоо толгойн албан татварын зарцуулалт, тайлагналтын ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар малчдын татвар төлөлтийг нэмэгдүүлнэ
- 3.2.10 Малын хулгай болон авто машинд мал дайрагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд малын бүртгэлжүүлэлт, чип суулгах ажлыг зохион байгуулна.

### ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

#### 4.1 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- 4.1.1 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах бодлого баримтална.
- 4.1.2 Байгалийн дурсгалт газруудыг түшиглэн аялал, жуулчлалыг орон нутагт хөгжүүлэх бодлого баримтална
- 4.1.3 Сумын хэмжээнд усны нөөц, булаг шандын эхийг хамгаалах арга хэмжээг үе шаттай зохион байгуулна



- 4.1.4 Голын ай сав дагуу цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгийг ойжуулах санал санаачилгыг дэмжин, ойжуулалт хийнэ
- 4.1.5 Тэрбум мод үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж жилд 100.0 мянгаас доошгүй мод тариална
- 4.1.6 Хараа голын сав дагуу болон ойн сан бүхий газруудад тархсан хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулах
- 4.1.7 Нэгдсэн хогийн цэгийг хашаажуулах, түрж булшлах ажлыг үе шаттай зохион байгуулах
- 4.1.8 Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг үе шаттай зохион байгуулна
- 4.1.9 Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлнэ

## **ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

### **5.1 Дэд бүтцийг сайжруулах чиглэлээр:**

- 5.1.1 Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар иргэн, аж ахуй нэгжүүдээс гарсан санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 5.1.2 Гэр хороолол, амралт сувиллын газарт био жорлон төслийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлнэ
- 5.1.3 Соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх хүрээнд соёлын төвийн барилгын шинэчлэлтийг хийж, ашиглалтад оруулах
- 5.1.4 Сумын төвийн нийтийн орон сууцнуудыг хэрэглээний халуун устай болгож, ундны усны хатуулгыг бууруулах технологи нэвтрүүлнэ
- 5.1.5 Сумын төвд амины орон сууцны шинэ суурьшлын бүс байгуулна
- 5.1.6 Сумын төвийн хэсгийн дулаан, цэвэр, ба бохир усны инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 5.1.7 "Эмт наран" ОНӨААТҮГ-ын дулааны дэд станцын хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, барилгын засварын ажлыг хийж хэрэгжүүлэх
- 5.1.8 Сумын төвийн хэсгийн ундны усны эх үүсвэр дээр халдваргүйжүүлэх төхөөрөмж шинээр суурилуулах ажлыг хийж хэрэгжүүлэх
- 5.1.9 "Эмт наран" ОНӨААТҮГ-т үнс тээвэрлэх авто машин нийлүүлнэ
- 5.1.10 Усан сан болон гүний худгийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулах
- 5.1.11 Дулаан эрчим хүчний хэвийн ажиллагааг хангах хүрээнд цахилгааны нөөц эх үүсгүүрийн шинэчлэлтийг хийнэ
- 5.1.12 Сумын төвийн уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлнэ
- 5.1.13 "Хонгор хот" ОНӨААТҮГ-ын хэвийн ажиллагааг хангах хүрээнд олон үйлдэлт трактор машиныг нийлүүлнэ
- 5.1.14 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд хог тээврийн авто машинд парк шинэчлэлт хийнэ
- 5.1.15 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих инкубатор төв байгуулах ажлыг хийж хэрэгжүүлнэ

### **5.2 Буурал багт хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажил:**

- 5.2.1 Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлнэ
- 5.2.2 Сумын төвийн авто, зам явган хүний замыг нэмэгдүүлэх, засвар шинэчлэлтийг ажлыг тогтмол хийж хэрэгжүүлнэ
- 5.2.3 Гэр хорооллын иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлэх

- 5.2.4 Иргэдийн идэвхтэй амьдралын хэв маягийг нэмэгдүүлэх хүрээнд бялдаржуулах фитнес төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах
- 5.2.5 Гэр хорооллын хэсгүүдэд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг зохион байгуулна
- 5.2.6 Иргэдийн амьдрах орчныг сайжруулах хүрээнд Нарлаг хэсгийг цахилгааны нэгдсэн системд холбох ажлыг зохион байгуулна
- 5.2.7 Үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд Буурал багийн үерийн далангийн засвар шинэчлэлтийн ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 5.2.8 Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

### 5.3 Зулзага багт хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажил:

- 5.3.1 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хүрээнд "Малчдын төгөл" төслийг хэрэгжүүлнэ.
- 5.3.2 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор ногоон тэжээл тариалах талбайг хашаажуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, малчдын санал санаачилгыг дэмжинэ
- 5.3.3 Малчдыг өвөлжөө хаваржаандаа саадгүй нүүх боломжийг нэмэгдүүлэх хүрээнд Холбоо гармын гүүр засварын ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 5.3.4 Зулзага багийн төв рүү цахилгаан татах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

### 5.4 Салхит багт хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажил:

- 5.4.1 Үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд Салхит багийн үерийн далангийн засвар шинэчлэлтийн ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 5.4.2 Гэр хорооллын иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлэх
- 5.4.3 Салхит багийн Дотор зам засварын ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 5.4.4 Салхит багийн нийтийн эзэмшлийн орон сууцуудын гадна пассат шинэчлэлтийн ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 5.4.5 Салхит багийн нийтийн эзэмшлийн орон сууцуудын инженерийн шугам солих ажлыг хийж хэрэгжүүлнэ
- 5.4.6 Гэр хорооллын хэсгүүдэд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг зохион байгуулна
- 5.4.7 Иргэдийн амьдрах орчныг сайжруулах хүрээнд Салхит багийн гүүрний засвар шинэчлэлтийг ажлыг хийж хэрэгжүүлнэ

Хөтөлбөрийг бэлтгэсэн:

Хонгор сумын МАН-ын  
хорооны дарга



Н.Ганбаатар